

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн! АНХ ДЭГТААР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.ДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

26 дахь жилдээ № 31 (2295) 1974 оны 4 дүгээр сарын 22 ДАВАА

ЛЕНИНИЗМИЙН ИХ ЯЛАЛТ

К.Маркс, Ф.Энгельс нарын суут сургаалыг үргэлжлүүлэгч, пролетарийн шинэ маягийн нам ЗХУКН, Зөвлөлт төрийг үндэслэн байгуулагч, дэлхийн хөдөлмөрчдийн аугаа их жолоодогч багш В.И.Лениний төрсний 104 жилийн ойд Монголын ард түмэн манай гаригийн сайн санаат бүх хүн ардын хамт гүн хүндтгэлтэй ёслол тэмдэглэж байна.

В.И. Ленин бол пролетарийн хувьсгалчийн хамгийн гарамгай шинж чанар, суут оюун ухаан, бүхнийг даван туулах зориг, боолчлол дарлалыг үзэн ядах үзэл, бадрангуй хувьсгалт чанар, тууштай эх оронч, интернациональ үзэл, олон түмний бүтээлч хүчинд хязгааргүй итгэх итгэл, зохион байгуулагч цагшгүй суут чанарыг шингээсэн хүн байлаа.

Ленинизм бол империализмын болон пролетарийн хувьсгалын эрэн үе, колоничлолын сүйрэл, үндэсний эрх чөлөөний ялалтын эрэн үе, хүн төрөлхтөн капитализмаас социализмд шилжиж коммунист нийгэм байгуулах эрэн үеийн марксизм мөн. Лениний болон большевистүүдийн намын дэлхий дахины түүхэн гавьяа нь дэлхийн ууган социалист нийгэм байгуулах ажлын удирдан жолоодсон явдалд оршино.

Хүн төрөлхтний түүхэнд шинэ эрэн үеийг нээсэн Октябрийн социалист их хувьсгалын ялалтаар социализм, коммунизмд улс түмний дэвшил хөгжих гол замын эх нь тавигдсан юм.

Орон бүхний ажилчин анги, хөдөлмөрчид, дэвшилт хүчнүүд октябрийн гэгээн саруул замаар итгэл төгс урагш давшиж, түүхийн хүнд бэрх сорилт шалгалтыг туулан давж шинэ шинэ ялалтыг хийсээр бай-

Дэлхийн хувьсгалт үйл явц өрнөх бэхжиж үнэхээр интернационалист шинж чанартай болж олон улсын коммунист хөдөлгөөний гол ололт болон дэлхийн социалист систем империализмын эсрэг тэмцлийн шийдвэрлэх хүч, орчин үеийн түүхэн хөгжлийн үндсэн хандлагыг тодорхойлох хүчин болж бэхжлээ.

Октябрийн социалист хувьсгалын ялалтын үр дүнд бүрэлдэн тогтсон олон улсын ажилчин анги, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний холбоо нь улс түмний эрх чөлөө, тусгаар тогтнол, нийгмийн дэвшлийн нэн чухал хүчин зүйл болж байна.

ЗСБНХУ-ын олон үндэстэн ястан ард түмэн Лениний намынхаа мэргэн удирдлагын дор түүхийн ахар богино хугацаанд улс орноо социалист ёсоор үйлдвэржүүлэн, хөдөө аж ахуйг хоршооллон, соёлын жинхэнэ хувьсгал өрнүүлж хөгжингүй социалист нийгмийг амжилттай байгуулан хүн төрөлхтний саруул ирээдүй коммунизмын замаар урагшлан давшиж байна. Зөвлөлтийн эдийн засгийн одоогийн хүч чадал өсч 1940—1970 онд улс ардын аж ахуйн нийт бүтээгдэхүүн 8,1 дахин, бүх салбарын үйлдвэрлэлийн үндсэн фонд 7,5 дахин түүний дотор аж үйлдвэрийнх 11 дахин өсч хөдөлмөрийн бүтээмж аж үйлдвэрт бараг 5 дахин, хөдөө аж ахуйд 3,3 дахин өсчээ.

Зөвлөлт Холбоот Улс өдөрт 2 тэрбум рублийн нийгмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргаж байгаа нь 1930-аад оны эцсийн нэг өдөрт үйлдвэрлэн гаргаж байснаас 10 дахин их байна.

Октябрийн аугаа их хувьсгал нь Монголын ард түмнийг эх орноо хөгжүүлэх хэтийн саруул төлөвийг нээж тэмцлийн нь туйлын зорилгыг зааж өгсөн юм.

Ленинизмын удирдлага болгож дэлхий дахины ач холбогдол бүхий шинэ замаар улс орноо хөтлөн жолоодсон явдалд МАХН-ын хүч чадал, түүхэн гавьяа орших бөгөөд энэ бол монголын ард түмний зүй ёсны бахархал мөн.

Иймээс манай орны бүх коммунистууд нийт хөдөлмөрчид энхийн хайрт МАХН-аа улам нягт хүрээлж, эх орондоо социализм байгуулж дуусгах эрхэм дээд үйлстээ шинэ амжилт олж их багш Лениний үзэл санааг монгол нутагт үеийн үед өргөн мандуула.

Аугаа их Лениний алдар нэр, үйл хэрэг үүрд мөнх.

Лениний ойд ...

Лениний мэндэлсний 104 жилийн ой угтаж зохиосон өндөр бүтээлийн уралдаанд НААУ-ний газрын оёдлын 1 дүгээр ээлж, хивс, нэхмэлийн тасар, 1 улирлын төлөвлөгөөг 123,7—136,6 хувь, оёдолчин Содном, Р.Ичинхорлоо, Долгор, Нэргүй, Цэрэн, Хишигхүү, хивсчин Маанжий, Зэсэндэг, Нарантуяа нар төлөвлөгөөг 78—100 хувь нар давуулан биелүүлэв.

д.ХИШИГЧУЛУУН

УРЬДАХ УЛИРЛЫН ДҮН, ОДООГИЙН ЗОРИЛТ

Саяхан аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны гишүүдийн хурлаар аймгийн аж ахуй, соёлын төлөвлөгөөт ажлын 1974 I улирлын дүнгийн тухай статистикийн товчооны дарга Х.Нацагдоржийн сонсголыг хэлэлцэв.

Тус хуралд тавигдсан сонсголоос үзэхэд манай аймгийн бүтээлч хөдөлмөрчдийн шаргуу хөдөлмөрийн үрээр төл бойжилт 99,3 хувьтай, малын зүй бусын хорогдол өнгөрсөн оны мөн үеийнхээс 24,1 хувиар багасан, үйлдвэр аж ахуйн газрууд I улирлын нийт бүтээгдэхүүний төлөвлөгөөг 111,9 хувиар биелүүлжээ.

Гэвч Алтанбулаг, Баянзүрх, Бүрэн, Заамар, Лун, Эрдэнэсүмд сумд зүй бусын хорогдлоор, Баяндэлгэр, Бүрэн, Жаргалант, Заамар Эрдэнэ сумд төл бойжилтоор бусад сумдаас хонорч байна.

Аймгийн ХБ-ийн байгууллагууд бэлтгэлийн 40 нэр төрлийн зүйлээс 20-ийг нь биелүүлээгүй, ХБ-ийн 4 анги бараа борлуулах төлөвлөгөөг тасалдуулжээ.

Мөн нийтийн хоол, бараа гүйлгээний хэмжээ урьд оны мөн үеийнхээс буурсан байна.

Ардын боловсрол, эрүүлийг хамгаалах байгууллагууд улирлын төлөвлөгөөт үзүүлэлтийг бүгдийг нь тасалжээ. Аж ахуйн гэрээний сахилгыг зөрчих, ажлын цаг ашиглаат, хөдөлмөр зохион байгуулалт хангалтгүй байгаагийн улмаас үйлдвэр аж ахуйн газрууд улирлын бүтээгдэхүүний нэр төрлийн төлөвлөгөөт нилээд зүйдүүдийг тасалдуулжээ.

I улирлын ажлын байдлаас дүгнэлт хийж, урьдах улирлын дутууг II улиралд нөхөн гүйцэхэд бүх ажлыг чиглүүлэхийн чухлыг тус хурал онцлон заалаа.

Юуны урьд төл бойжуулалтын талаар олсон амжилтыг бататган, урьд онуудад төлийн хорогдлын 50 шахам хувь нь II улиралд гарч байсныг анхаарч ажиллах, бэлтгэлд өгөх малыг нэгбүрчлэн тэжээж шахаж бордох, үнээ, гүүнд хээл авахуу-

лах ажлыг урьд жилүүдээс онцгой чанартай явуулах, малыг гэнэтийн аюулаас хамгаалах нь одоо үеийн нэн тэргүүний зорилт болж байна.

Түүнчлэн нөөц бололцоог ашиглах асуудлыг өрөөсгөл ойлгож байгаа дутагдлыг арилгаж, санхүү материал хөдөлмөрийн бүхий л нөөцийг дээд хэмжээгээр ашиглахад бүх хөдөлмөрчдийн идэвх санаачлагыг өрнүүлэх хэрэгтэй гэж заав.

Малын арьс, ширлэг шуурхай цуглуулж, хөөвөр, хялгас бэлтгэх ажлыг богино хугацаанд гүйцэтгэхийг худалдааны байгууллагуудын чухал зорилт болголоо.

Социалист уралдааны үүргийг хянал үзэж нэмэлт үүрэг авч, тэжээлдээ урьд жилийн амжилтаас доогуургүй үүрэг авах зарчмыг хатуу баримтлаж энэ оны эхний хагас жилийн төлөвлөгөөг 23 хоногийн өмнө биелүүлэх зорилт дэвшүүлэв.

Д.БАДАГЧ

Малын зүй бус хорогдлыг багасгах комиссын ажлаас

ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙВ

Сэргэлэн сумын малын зүй бусын хорогдлыг багасгах комисс «Хөшиг» бригадын үнээний фермийн Гэлэгцүтэм ахлагчийн суурийн малын зүй бусын хорогдолд шалгалт хийв.

Энэ суурийнхан суурийн том малын 4,4 хувийг, зөвхөн энэ оны эхний улиралд 8 төл хорогдуулжээ.

Малын зүй бусын хорогдол гарсан шалтгаан

нь малчдын харнуцлага, малын арчилгаа, тэжээл-лэг, суурийн ариун цэвэр муу байснаас болжээ.

Мөн суурьт анхан шатны тоо бүртгэлийг хөтөлөөгүй, тэжээлийг тооцоогүй зарцуулж нэг малд өгөх тэжээлийн нормыг 4—5 дахин нэмэгдүүлэн зарцуулж байжээ.

Түүнчлэн саасан сүүнээс олох ашиг бүх зарцуулсан тэжээлийн үнэний 50 хувьтай тэн-

цэж үлэмж алдагдал гаргажээ.

Иймд сумын комиссоос суурийн ахлагч Гэлэгцүтэмд ажлын зарцуулалтыг шаардан хүлээг ажиллах арга барилыг дэлгэрүүлэн, олон түмний идэвх хөдөлгөөн, хамтат ажиллагааг өрнүүлэн малын зүй бусын хорогдлыг таслан зогсоох малын харнуцлага малаагаа, арчилгаа тэжээлийг сайжруулж ажиллахыг анхааруулав.

Н.САНГИ-РАГЧАА

Сум, хот, хороодын 1974 оны 1 дүгээр улирлын социалист уралдааны дүн

Сум хот, хороод	Байр	
	1973 оны 1 улирал	1974 оны 1 улирал
Угтаал	1	1
Баянцагаан	10	2
Эрдэнэсант	22	3
Батсүмбэр	8	4
Баян	21	5
Баянцогт	17	6
Баян—Өнжүүл	19	7
Борнуур	3	8
Баянчандмань	4	9
Дэлгэрхаан	12	10
Сэргэлэн	11	11
Баянжаргалан	5	12
Лүн	15	13
Өндөрширээт	7	14
Зуунмод	24	15
Эрдэнэ	13	16
Алтанбулаг	9	17
Баянзүрх	23	18
Баяндэлгэр	6	19
Бүрэн	16	20
Мөнгөнморьт	20	21
Заамар	18	22
Жаргалант	2	23

Тайлбар: Сумдын 1 дүгээр улирлын социалист уралдааныг төл бойжилт, малын зүй бусын хорогдол, техник засварыг гол болгож дүгнэв.

Үйлдвэр аж ахуйн газруудын 1974 оны 1 дүгээр улирлын социалист уралдааны байр

Үйлдвэр аж ахуйн газар	Байр	
	1973 оны 1 улирал	1974 оны 1 улирал
Зам анги	4	1
Авто бааз	11	2
Хүнсний комбинат	1	3
Барилга контор	8	4
НААҮГ	5	5
Ойн аж ахуй	9	6
Холбооны газар	7	7
Эмийн сангуудыг удирдах контор	2	8
Хэвлэх үйлдвэр	6	9
ХБУ газар	2	10
Баянцогтын тэжээлийн үйлдвэр	=	11
Архустын ТАА	=	12
Эрдэнэсантын тэжээлийн үйлдвэр	=	13
Угтаалын тэжээлийн үйлдвэр	=	14
Баянчандманий засварын газар	12	15
Усны аж ахуй	3	16

КОММУНИСТ СУББОТНИК—ХӨДӨЛМӨРИЙН БАЯР

Шинэ нийгмийг цогцлон байгуулах эхлэл нь болсон Москва—Казаны төмөр замчдын субботникийг В. И. Ленин «Коммунизмын жинхэнэ эхлэл» гэж нэрлэн «Их санаачилга» гэдэг алдарт зохиолоо бичсэн юм.

В. И. Лениний «Их санаачилга» зохиол нь социализм коммунизмыг байгуулж байгаа одоо үед бүр ч ач холбогдолтой юм.

Иймээс МАХН—ын Төв Хорооноос саяхан бүх нийтийн субботникийг бэлтгэж явуулах тухай чухал тогтоол гаргалаа.

Бүх нийтийн субботникийг манай социалст эх орон даяар В. И. Лениний мэндэлсний 104 жилийн ойг тохиолдуулан энэ 4 дүгээр сарын 21-ний өдөр нээж үйлдвэр, барилга, аж ахуйн газрын ажилчдаас илүү бүтээгдэхүүн үйлдвэрлэх журмаар нийтийн субботник хийх өдрийг 5 дугаар са-

рын 5—ны Ням гаригт хөдөлмөрийн хамт олон хүн нэг бүрийн нэр төрийн хэрэг болгон үзэл суртал зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахаар шийдвэрлэсэн билээ.

Социалист уралдаанд шалгарлагчдын чуулга уулзалтаас V таван жилийн төлөвлөгөөг 4 жилд биелүүлэх, 6 өдрийн ажлыг 5 өдөрт хийж 1974 онд төлөвлөгөөг зорилтоо БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойн өмнө биелүүлэх эх оронч сайхан хөдөлгөөнийг өрнүүлэх талаар гаргасан уриалгыг манай аймгийн нам, улс, олон нийтийн байгууллага, нийт хөдөлмөрчид баяртай хүлээн аваад дотоод нөөц бололцоогоо судлан уралдааны үүргээ дахин хянаж нэмэлт үүрэг авч ажилласны үр дүнд аймгийн хэмжээний I улирлын төлөвлөгөө амжилттай биелэгдлээ.

Саяхны байдлаар төлөх эх малын 62,8 хувь

нь төлөж 339,7 мянган төл бойжиж, бойжилт нь 99,3 хувьтай байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулбал төл бойжилт 35,6 хувь дээгүүр, ХАА-н техник засвар 88,9—97,1 хувьтай өнгөрсөн оныхоос 1,2—10 хувиар илүү байна.

Үйлдвэрүүд нийт бүтээгдэхүүний төлөвлөгөөг амжилттай биелүүлсний дотор аймгийн Хүнсний комбинат I дүгээр улирлын бүтээгдэхүүний төлөвлөгөөг 119 хувь, Солины үйлдвэр 107,4 хувь, НААҮГ 108,5 хувь, Ойн аж ахуй 110,1 хувиар биелүүлсэн нь урьд онтой харьцуулбал 26—33 хувиар давуу байна.

Ийм сайхан эх оронч хөдөлгөөнийг улам далайцтай өрнүүлж цаг үеийн ээлжит зорилтыг амжилттай биелүүлэхэд коммунист субботник ихээхэн ач холбогдлоо өгдөггүйг өчигдөрийн субботник харуулав. Цаашид;

**Малын зүй бусын
ХОРОГДОЛТОЙ ТЭМЦЬВЭ
ЗОХИОСОН АЖЛЫНХАА ҮР
ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЬЕ**

Эрдэнэсант, Дэлгэрхаан, Бүрэн сумдын малын зүй бус хорогдлыг багасгах комисс төлөвлөгөөтэй ажиллан мал хорогдлын 3—5 жилийн судалгаа гарган оновчтой ажил зохиож байна.

Үүний үрээр энэ оны I дүгээр улиралд гарсан малын зүй бусын хорогдлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 139—500 гаруй малаар цөөрсөн байна.

Гэвч Эрдэнэсант суманд 520, Дэлгэрхаанд 269, Бүрэнд 579 мал зүй бусаар хорогдож, Эрдэнэсант суманд 160, Дэлгэрхаанд 336, Бүрэнд 696 мал хээл хаяжээ.

Эдгээр хорогдлын шалтгаан нь мал тэжээж байгаа нилээд суурь ядарч доройтсон малыг гардан тэжээхгүй, хивэг, багсармал, бүдүүн тэжээлийг

хэрчиж жижиглэн дэвтээж өгөөгүйгээс зарцуулсан тэжээл зохих үр дүнгээ өгөхгүй байгаа ба малыг доройтсон хойно нь тэжээж байгаагаас болж тэнхэрч чадахгүй үхэх, хэт орой бэлчээж, эрт хотлуулснаас идэшлэх цаг нь багасдаг тал байн. Ядарч доройтсон буюу өсвөр насны малыг хэт олноор сууриж, дадлага туршлага багатай хүмүүсээр маллуулснаас болж мал хорогдож байна.

Жишээлбэл: Бүрэн сумын Хайрхан бр игад,

Ш. Жанчив гэдэг хот суурин газар олон жил суусан бөгөөд хоёрхон жил мал маллаж байгаа хүнд олон тооны төллөх зусаг хонь, ямаа өгөөд төлийн бэлтгэлийг муу хангуулж, биечилсэн туслацааг оройтуулж оны эхнээс эхлэн төл мал хорогдсоор байхад МАА-н мэргэжилтнүүд суурьшилтай ажиллаагүйгээс болж 40 гаруй төл хорогдож нилээд мал хээл хаяжээ.

Төл ба том мал хороосон олонхи суурийн малчид усны ач холбогдлыг дутуу үнэлж, хэвтэр бууцыг бохир, хүйтэн байлгаж жижиг хашаанд олон мал чихэлдүүлэн хийж, хээлийг муу хамгаалж, арчилгаа малаага, ажиглалт хяналтыг сулруулснаас болж олон мал хээл хаяулжээ.

Иймэрхүү дутагдал Дэлгэрхаан сумын хоньчин С. Цэрэнбат, Г. Шарав, Б. Мияа, Бүрэн сумын хоньчин С. Жамъян, Д.Цэрэнням нарын суурьт үзэгдэж байна.

Ер нь малын эмч мэргэжилтнүүд зохих ёсоор ажиллахгүй, өвчтэй малыг өөрсдөө эмчлэн үр дүнг үзэхийн оронд малчдад эм тарааж өгснөөр ажлаа хязгаарлах, өвчтэй малын дуудлага ирэхэд хэвшүүн хойрго хандах, суурь малчдаар биечлэн явж тогтож ажиллахын оронд хурдан унаагаар

хөдөлгөн «буухна элч» мэт довтолгож, малын өвчнийг дор бүр нь оношлохгүй, үхэл хорогдлыг яаралтай зогсоох талаар шуурхай арга хэмжээ авахгүй байгаа ажээ.

Цаашид малчдад зомол эмнэлгийн анхны мэдэгдэхүүн, мал тэжээх аргыг эзэмшүүлэх нь чухал юм.

Ялангуяа хивэг, багсармал тэжээл хоёрыг яаж исгээж зөөлрүүлж, багсарч өгөх аргыг сайтар эзэмшмээр байна. Нөгөө талаар малчдын ахуй нөхцөл, соёлжилтыг сайжруулах, тэдний ажиллах боломжийг хангах, хөдөлмөрийн бүтээлийг дээшлүүлэх хэрэгтэй.

Малын зүй бус хорогдлыг багасгах талаар зохиож байгаа ажилд гарч буй тэргүүний арга ажиллагааг бусдад нь эзэмшүүлэх зорилгоор тэргүүн туршлагын үзүүлэх сургууль зохиож семинар зөвлөлтөөн хийх, том мал ялангуяа төл малын хорогдлыг багасгах ажилд социалист уралдааныг далайцтай өрнүүлэх нь чухал.

Зарим суурийн малчид радио хүлээн авагчгүй, байвч ажилгүй, тэжээлгүй, захирсан хэвлэл нь 7 хоног бүр очихгүй байв.

Иймээс дээрхи дутагдалдаа дүгнэлт хийж, амжилтаа бататгах, малын зүй бус хорогдлыг эрс багасган ялангуяа урин дулааны улиралд нэг ч мал хороохгүй байх талаар бололцоотой бүх арга хэмжээг авах нь эдгээр сумын нам, захиргаа, олон нийтийн байгууллага, МАА—н мэргэжилтэн, нийт малчдын чухал зорилт болж байна.

Манай тусгай сурвалжлагч
Б. ТОГООХҮҮ

5 дугаар 5—ны өдрийн Ням гаригт хийх нийтийн субботникийн гол зорилт нь үйлдвэр, аж ахуй, соёлын бүх байгууллага ажлаа сайжруулах далайц үр нөлөө бүхий арга хэмжээ болгон явуулахад оршино.

Нийтийн субботникийн өдрүүдэд нийт ажилчин, албан хаагчид, дунд сургуулийн сурагчид өндөр бүтээл гарган нэг өдрийн цалин хөлстэй тэнцүү буюу илүү хэмжээний ажил хийж хуримтлалд оруулах юм.

Иймд субботникийн бэлтгэл ажлыг өргөн далайц үр дүнтэй болгох талаар зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авах нь нам, улс, олон нийтийн байгууллагуудын чухал зорилт болж байна.

Мөн субботникийн ажлыг V таван жилийн төлөвлөгөөний бат суурь дэвсгэр болох 1974 оны аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг амжилттай биелүүлэх хөрөнгө материал түүхий эд хэмнэх үйлд-

вэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлж хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, дотоод нөөц бололцоог дээд хэмжээгээр ашиглах ажилтай нягт хослон урьдчилсан нарийн судалгаа бодож боловсруулсан төлөвлөгөөний үндсэн дээр явуулах нь чухал.

Энэ эх оронч хөдөлгөөнийг манай намын гишүүд, ажилчин анги манлайлан хошуучлах ёстой.

Бүх нийтийн субботник хөдөлмөрийн баярын энэ өдөр өндөр амжилт гаргах гол үндэс нь субботникийн бэлтгэлийг үйлдвэр, албан газар бүхэн сайн хийж хөдөлмөрийн тайбай, ажлын байр бүхнийг зохион байгуулалтын удирдлагаар хангах, хяналт шалгалтыг шуурхай явуулж ажилд гарсан тэргүүний туршлагыг сурталчлах, үзэл суртал зохион байгуулалтын нэгдлийг сайтар хангаснаар биелэгдэх юм.

Д. ДУЛАМЖАВ

Бүх ард түмний социалист уралдаан

Мөнгөнморьт, Баяндэлгэр, Баянжаргалан сумдын хөдөлмөрчид 1973 оны бүх ард түмний социалист уралдаанд авсан үүргээ амжилттай биелүүлжээ.

Эдгээр сумдынхан урьд оны адил оны эхэнд малчид хөдөлмөрчдөөр үүрэг авахуулах ажлыг зохиосон байна.

Мөнгөнморьт сум төлчдөөр энэ оны уралдаанд үүрэг авахуулж, түүнээ 7 хоног тутам дүгнэн цуваагаар байр эзлүүлэн 5 төгрөгийн цалинт дарцаг шилжүүлж байна.

Тус сум-нэгдлийн саальчин, Ардын Их Хурлын депутат А. Ичинхорлоо V таван жилд 50800 литр сүү саах төлөвлөгөөг 21000 литрээр давуулж, төлөвлөгөөт таван жилийн тэргүүн эгнээнд хошуучилж, 5 жилд 7 жилийн ажил хийх нэмэлт үүрэг аваад ажиллаж байна.

Баяндэлгэр сумын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, ҮЭ-ийн зөвлөлөөс малчид, төлчид саальчдад 1974 оны социалист уралдааны хуудас олгосны гадна сумын ХЗЭ-ийн хорооноос МХЗЭ-ийн гишүүд залуучууд, илгээлтийн эзлэд хэвлэмэл хуудас гардуулж, бойжуулах төл, нэг малаас авах ашигшм, мэдлэг боловсролоо ахиулах, эмнэг хангал сур-

гах талаар өгөгдсөн төлөвлөгөө, авсан үүргийг нь бичиж өгч үүргийн биелэлтийг долоо хоног бүр дүгнэж байр эзлүүлж шагна урамшуулж байна.

Саяхан социалист уралдаанаа дүгнэсэн байдлыг үзэхэд «Галуут» бригадын хоньчин Лувсандондог, сумын аварга Очир, «Байдлаг» бригадын саальчин Ж. Сэр-од, О. Долгоржав, Г. Балам, сумын тарга хүчний аварга Н. Чойнжуур,

ажилд санаа тавиагүй нь харагдав.

Ер нь энэ 3 суманд зөвлөхөн уралдаанд үүрэг авахуулснаар санаа амарч, түүнийг сурталчлах, дүгнэх явдал хангалтгүй байна. Жишээлбэл: Баяндэлгэр сумын «Байдлаг», «Галуут», Мөнгөнморьт сумын «Бүрх» бригадын хоньчид малчдын уралдааныг бүтэн нэг улирал өнгөрөөд байхад дүгнээгүй байгаагаас одоогийн байдлаар

даа үр дүн муутайхан явж ирдгээс болжээ.

Мөн уралдааны дүнг 3,57 хоногоор гаргаж байгаа боловч дөнгөж баярын бичиг, цалинт дарцаг гардуулчихаад буцдаг «буукиа» төлөөлөгч нар дээрхи сумдын аль алинд нь байна.

Иймд төлчид малчдын уралдааныг дүгнэхдээ ойр хавийн сууриудад нь хэний суурь хошуучилж явааг нь хэлж ярьж таинуулдаг, уралдаанд түрүүлэгчдийг хамт олны нь өмнө хөхүүлэн урамшуулж баяр хүргэх, ханын болон цахилгаан сонин, мэдээлэх хуудас аялуулж, түүгээр хамт олонд мэдэгдэж сурталчилдаг байх нь чухал юм.

Мөн энэ сумдын уралдааны комиссоос сум бригад суурь хоорондын уралдааныг улирал тутам дүгнэж, ололтыг батгаж дутагдлыг засуулах талаар шуурхай арга хэмжээ авч баймаар байна. МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг угтсан бүх ард түмний социалист уралдааныг өрнүүлэн, түүнийг удирдах явдлыг оновчтой болгож үр нөлөөг нь дээшлүүлэх явдал чухал байна.

Манай сурвалжлагч Л. ГУНГААБУУ



Таван жилийн төлөвлөгөөг 2 жил 1 сарын өмнө биелүүлсэн НААҮГ-ын оёдолчин Б. ХИШИГ-НҮҮ



Төлөвлөгөөг 2 жил 4 сарын өмнө 107,3 хувь биелүүлсэн мөн газрын оёдолчин Б. ДАШ-ЦЕРМАА

УРАЛДААНЫГ ОНОВЧТОЙ УДИРДЪЯ

коммунизмын оронд жуулчлаад ирсэн саальчин Цэрэндолгор нар уралдааны түрүүг олон удаа авчээ. Эдгээр сумд энэ жилийн уралдаанд үүрэг амлалт авахуулах ажлыг ингэж зохион байгуулсан боловч дутагдал нилээд байна.

Баянжаргалан сум-нэгдлийн «Баян эрхтий» бригадын хоньчин Халтарын зэрэг хэд хэдэн сууриуд социалист уралдаанд авсан тодорхой үүрэггүй байлаа. Энэ нь тус сум-нэгдлийн захиргаа ҮЭ-ийн зөвлөлөөс он гарсаар бүтэн нэг улирал өнгөрөөд байхад лав л энэ бригадын малчдад уралдаанд үүрэг амлалт авахуулах

уралдаанд авсан үүрэгээ биелүүлсэн, тэрч байтугай эхний улиралд саальчин гэхэд л төлөвлөгөөт сүүнийхээ хэдэн хувийг саагаад байгаа, төлчид, малчид МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлын заалтаас хэдэн төл илүү бойжуулах үүрэг авснаа мэдэхгүй байлаа.

Энэ нь сумын захиргаа, ҮЭ-ийн зөвлөлөөс ялангуяа төлчдийн уралдааны биелэлтийг зөвхөн төдөн хонингоос төчнөөн хурга бойжуулаа гэсэн ам тоо авч, жинхэнэ суурь бригадаар явж, биечилэн шалгаж, дүгнэж, шагнаж урамшуулах ажил зохиогоогүй төлийн сууриудаар явах-

Төлчид уралдаж байна

Эрдэнэсант, Дэлгэрхаан, Бүрэн сум-нэгдлүүдийн төлчдийн дунд 3,7, 10 хоногийн болзолт уралдаан, тэргүүний суурьт шилжин явах «төл бүрэн» гэсэн цалинт дарцаг, ихэр төлийн гэрчилгээ, мөнгөн шагнал, суурь бригадын хоорондох хэлз уралдаан зэрэг төлчдийн дунд зарласан социалист уралдааны олон хэлбэр нь малчдын урам зоригийг сэргээж, олсон амжилтаа бататгаж, шинэ шинэ амжилт гаргахад нь улам их түлэх өгсөөр байна. Эрдэнэсант сумын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, ҮЭ-ийн зөвлөл болон «Саруул-амьдрал» нэгдлийн зөвлөлийн шөф аймгийн ХБҮГ бусад шөф байгууллагын хэмжээгээр төлчид малчдын дунд зарласан урт богино хугацаатай социалист уралдаанд «Сайхан» бригадын хоньчин БНМАУ-ын аварга малчин П. Базаррагчаа, аймгийн хошой аварга Т. Сүрэнхүү, «Баян-уул» бригадын хоньчин С. Чимэд, Д. Дашням, Ш. Чимэд нарын зэрэг олон малчид гарсан төлөө нэгч хорогдолгүйгээр 5—69 ихэртэйгээр бүрэн мэнд бойжуулаад хошуучилж явна.

Тус сумын малчид социалист уралдаанаар жи- гүүрлэн төлийн төлөө ту-

лалдааны талбарт өндөр амжилт гаргаж төлчдийн дунд зарласан социалист уралдаанд түрүү магнай алахгүйн тулд урьд оны эхнээс төлийн бэлтгэлээ базааж малын тарга хүчийг жилийн дөрвөн улиралд жигд тогтоон чам байруулж чаддаг юм байна. Дэлгэрхаан сумын хэмжээгээр төлчдийн дунд зарласан социалист уралдаанд аймгийн депутат А. Дагвадорж, хоньчин У. Чоймбол, Д. Осорхүү, Б. Дорж нар гарсан төлөө 7—11 ихэртэйгээр бүрэн мэнд бойжуулж хошуучилж яваа ба социалист уралдааны айргийн тавын барианд ихэвчлэн илгээлтийн эзэд, залуу малчид орж байна.

Тухайлбал: МХЗЭ-ийн илгээлтийн эзэн Т. Даш-зэвэг, Д. Оюун, залуу хоньчин Д. Цолмон, Ц. Бямба, Ш. Дэлэгжид, аймгийн депутат Б. Ханд, МХЗЭ-ийн Төв Хорооны «Тэргүүний малчин залуу» алтан медальт хоньчин Н. Механик зэрэг залуучууд төл бойжуулалтын ажлаараа сумынхаа аваргуудтай өрсөлдөж байна.

Бүрэн сумын төлчид, малчдын дунд зарласан социалист уралдааны явц,

(Төгсгөл нь IV нүүрт)

ЧУУЛГА УУЛЗАЛТЫН УРИАЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ

Саяхан аймгийн үйлдвэр аж ахуйн газруудын мастер, эд шалгагчид, инженер техникийн ажилтан, эдийн засагч, санхүүгийн мэргэжилтэн, үйлдвэр аж ахуйн газруудын нам, захиргаа, олон нийтийн байгууллагын дарга нарын зөвлөлтөөн болов.

Зөвлөлтөөнд «1973 оны бүх ард түмний социалист уралдаанд түрүүлэгчдийн чуулга уулзалтын уриалгыг дэмжиж, 1974 оны улс ардын аж ахуй соёлын төлөвлөгөөг 11 дүгээр сарын 15-ны дотор амжилттай биелүүл» гэсэн илтгэлийг аймгийн Намын хорооны нарийн бичгийн дарга Д. Дамбажамц тавьж хэлэлцүүлэв.

Манай аймгийн үйлдвэрүүд 1973 онд 13,6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, жилийн төлөвлөгөөг 120,9 хувиар биелүүлэн, 23 сая төгрөгийн бүтээгдэхүүн илүү үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оныхоос 4 сая 45 мянган төгрөгөөр буюу 42,2 хувиар давжээ.

Аймгийн Хүнсний комбинат, сонин үйлдвэр зэрэг газрууд сүүлийн 3 жилийн турш сар бүрийн төлөвлөгөөг тогтвортой биелүүлдэг баялаг туршлагатай болжээ.

Гэвч нэр төрлийн

төлөвлөгөөг таслах, жил улирал сарын эцэс рүү довтолгож, чанар муутай бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал зарим үйлдвэрүүд дээр гарсаар байна.

Ялангуяа хамт олон, хүн нэг бүрийн социалист уралдааны үүргийг өнгөрсөн оны гүйцэтгэлээс дээгүүр авахуулж, нөөц болдоог дээд хэмжээгээр дайчлан ажиллахгүй, урьдах амжилтандаа тайвшраг байдал үзэгдэж байгааг илтгэгч тэмдэглэв.

Илтгэлтэй холбогдуулж «Анхдугаар таван жил» сонин эрхлэгч Д. Товуу, Хүнсний комбинатын дарга Д. Барьд, Зам ангийн мастер Дамбадгва, Хивсний мастер Жамсран нарын олон хүн үг хэлж нэмэлт үүрэг амлалт авав.

Зөвлөлтөөнөөс аймгийн Хүнсний комбинатын туршлагаар цех тасаг хүн нэг бүр сар бүрийнхээ төлөвлөгөөг жигд биелүүлсний үндсэн дээр жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 11 дүгээр сарын 15-ны дотор үзүүлэлт нэг бүрээр ханган биелүүлсэн байх.

—Социалист уралдааны үүргийг ээлж цех тасаг хүн бүр дээр дахин нарийвчлан шалган нөөц болдоогоо дайчилж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс

бууруулахгүйгээр үүрэг амлалт авахуулах;

—Бүтээгдэхүүний чанарыг сайжруулахын тулд ажилчин бүхэн чанар шалгагч байх ёстой гэсэн уриан дор чанарын үзлэг шалгалтыг ажлын байр, дамжлага бүхэнд явуулж, чанарын талон гэрчилгээг сонин үйлдвэр, хүнсний комбинатын туршлагаар зарцуулалт хадгалалт хамгаалалтыг сайжруулан, материалын өөдөс хаягдлаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлдвэртээ орлого оруулж байгаа Ойн аж ахуй, Барилга угсралтын конторын туршлагыг нийт үйлдвэрүүдэд нэвтрүүлэх;

Худалдаа үйлчилгээнд соёл боловсон байдал тууштай нэвтрүүлж, хүн бүрийг гомдоохгүйн төлөө хөнгөн шуурхай үйлчилж, үйлдвэрлэл үйлчилгээний дэвшилттэй арга барилыг бүтээгдэхүүн хэрэгжүүлэхэд социалист уралдааныг удирдлагын гол арга барил болгох зорилт дэвшүүлээ.

Р. БАЯРСАЙХАН

В. И. ЛЕНИНИЙ БҮТЭЭЛҮҮД ХЭВЛЭГДСЭН НЬ

В. И. Лениний бүтээлүүд зөвлөлт засгийн жилүүдэд ЗХУ-д 11,8 мянга гаруй дахин 444 сая хувиар, зөвлөлтийн болон х а р ь орны 102 хэд дээр хэвлэгдэн гарчээ.

1923—1970 онд В.И.Лениний сонгодог зохиолууд ЗХУ-д 504 дахин 19 сая 168 мянган хувь хэвлэгджээ. Төв Хорооны Оросын товчоо, большевикуудын намын Петербургийн хороонд илгээсэн бөгөөд урьд нь мэдэгдээгүй байсан захидлыг өнгөрсөн оны 4 дүгээр сарын 22-ны «Правда» сонинд нийтэлсэн юм.

Уг захидлыг Английн худалдаа, үйлдвэрийн эзэн А. Остемелом олж өгсөн байна.

1944 оноос эхлэн Болгар хэл дээр В. И. Лениний 200 гаруй зохиол бүтээл 3,0 сая хувь, БНПАУ-д В. И. Лениний зохиол бүтээлийн эмхтгэл тусгай бүтээлүүд 238 удаа 10 сая, Румынд

6,5 сая гаруй хувь, Чехословакт 360 гаруй ном зохиол нь хэвлэгдэн гарсны гадна 1970 онд В. И. Лениний зохиолын эмхтгэлийн 45 ботийг Чех хэлээр, 1972 онд Словак хэлээр хэвлэн гаргажээ.

«Сербиин Радничке» сонинд В. И. Лениний «Юу хийх вэ» зохиолын нэгэн бүлэг нийтлэгдсэний 70 жилийн ойг өнгөрсөн онд тэмдэглэсэн нь В. И. Лениний Югославт хэвлэгдсэн анхны бүтээл байв.

В. И. Лениний бүтээл анх 1932 онд Вьетнам хэл дээр гарсны гадна одоо Зөвлөлт-Вьетнамын хамтарсан хэвлэлээр Лениний зохиолын бүрэн эмхтгэл Вьетнам хэл дээр хэвлэгдэж байна. В. И. Лениний зохиол бүтээлийг хэвлэн гаргахын хувьд хөрөнгөтөн орнуудаас Япон, Латин Америкийн орнуудын дотор Аргентин, хөгжиж байгаа орнуудын дотор Энэтхэг улс тус тус 1 дүгээр байр эзэлж байна.

Японы коммунист Я.Кобая, В. И. Лениний бүтээлийг хэвлэлд бэлтгэх ажлыг 1930-аад оноос эхэлжээ.

Японд В. И. Лениний бүтээл 1320 удаа хэвлэгдсэний дээр Аргентин улсад «Социализм ба дайн» гэдэг зохиол 1918 онд Испани хэлээр хэвлэгдэн гарчээ. Аргентиний Коммунист намыг нууц ажиллагаатай хүнд нөхцөлд байх үед нь В. И. Лениний зохиолуудын бүрэн эмхтгэл анх удаа Испани хэл дээр хэвлэгдсэн түүхтэй. Аргентиний коммунистууд В. И. Лениний мэндэлсний зуун жилийн ойгоор мөн зохиолын бүрэн эмхтгэлийн 2 дахь хэвлэлийг гаргажээ.

1972 онд тус оронд В. И. Лениний 107 бүтээл, хагас сая гаруй хувиар хэвлэгдсэн байна.

В. И. Лениний бүтээлүүд Энэтхэгт 395 дахин, Бангел, Хинд, Урд, Телуг болон бусад хэл дээр хэвлэгдэн гарчээ.

Н. ХАНДСҮРЭН



Эрдэсэнт сумын «Саруул-амьдрал» нэгдлийн «Сайхан» бригадын хоньчин М. Дамдинсүрэнгийн суурьхан 548 хонь, ямаа төллүүлэхээс 480-ыг төллүүлээд гарсан тоолоо 8 ихэртэйгээр бүрэн мэнд бойжуулж байна.

Зураг дээр: Төлчид хүргэж тэмдэж байгаа нь.

ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛҮҮЛЭВ

Баян-Өнжүүл сумын ХБ анги 1974 оны 1 дүгээр улирлын бараа, номын гүйлгээг 100—122,5 хувиар, түүхий эд, ангийн үсний 28 нэр төрлийн зүйлээс 24 нэр төрлийн зүйлийг 100—329 хувиар биелүүлж, аймгийн ХБ-ийн байгууллагуудын 1 дүгээр улирлын уралдаанд 2 дугаар байр эзлэв.

Ц. ЖАДАМБАА

Хаврын тариалалтын өмнө

Үйлдвэрлэлийн зөвлөлгөөн

Борнуурын САА-н үйлдвэрлэлийн зөвлөлгөөн саяхан болж 1973 оны үйлдвэрлэлийн ажиллагааны үр дүн, улсын тэргүүний тариаланчдын зөвлөлгөөний шийдвэр, 1974 оны зорилтыг биелүүлэх арга хэмжээний тухай хэлэлцэв.

Тус САА өнгөрсөн онд мал өсгөх улсын хөдөлшгүй төлөвлөгөөг 116 хувиар, улсын төлөвлөгөөт даалгавраа бүх үзүүлэлтээр 100-гаас дээш хувь, ургац хураах төлөвлөгөөг ургамлын төрөл бүр дээр нь 107,5—174 хувиар, улсад тушаах төмс хүнсний ногооны төлөвлөгөөг 02—12 хувиар давуулан биелүүлжээ.


Энэ амжилтаа улам бататган 1974 онд төмсийг

12 хоногт, үр тариаг 15, малын тэжээлийг 18, байнааг 18 хоногт, бусад тариалыг 5—8 хоногт багтаан агро-техникний ашигтай хугацаанд тариалж дуусгах, усалалтын системийн ашиглалтыг сайжруулж, таримал тус бүрийг цэнэг усалгаагаар услах, нэг талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэхийн тулд эрдэс ба минералын бордоогоор бордох зэрэг тодорхой зорилтуудыг дэвшүүлэн тавив.

Тус зөвлөлгөөнд оролцогчдоос сум САА-н малчид, ажилчин, ногоочид, механикжуулагчдыг 1974 онд газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлд улам их амжилт гаргахыг уриалж уриалга гаргав.

Д. ДОРЖДЭРЭМ

Манай зургийн уралдаанд



Айлын хаяа бараадуулсан Ажилладаггүй төлийн штаб

О. СУМЪЯА зурав

Төлчид уралдаж байна

(Төгсгөл. Түрүүч нь III нүүрт)

Үр дүн нь төдий л сайнгүй байгаа ч гэсэн МАХН-ын малчин гишүүд коммунист нийт малчид төлчдөө үлгэрлэн манлайлж ганц төлийн хорогдолгүй байгаа нь сайшаалтай хэрэг юм.

«Хайрхан» бригадын хоньчин О. Пагваан-найдал, «Булангаа» бригадын хоньчин Ш. Төмөр, «Баянцогт» бригадын хоньчин Ц. Мандалсүрэн зэрэг коммунистууд гарсан төлөө 3—11 ихэртэйгээр бүрэн мэнд бойжуулж «Төл бүрэн» гэсэн цалинт дарцаг авчээ.

Гэвч эдгээр сумдын төлчдийн дунд зарласан социалист уралдаанд хойшнд анхаарч, ойрын үед хийж мөрдүүштэй нилээд дутагдал байна.

Малчин бүр социалист уралдаанд бие дааж үүрэг аваагүй бөгөөд голчлон тэргүүний ажиллагаатай цөөн тооны малчид үүрэг авчээ.

УЛИРЛЫН УРАЛДААН ДҮГНЭВ

Угтаал, Жаргалант, Баянцогт сум-САА оны эхэнд социалист уралдаанд харилцан үүрэг амлалт авч, уралдаантай ажиллахаар гэрээ байгуулж, эхний улирлын гэрээний үүрэг, уралдаанаа саяхан Баянцогт сум САА-н төвд дүгнэв.

Социалист уралдааны гэрээнд дурдсан төл бойжуулалт, малын зүй бүсийн хорогдол, хаврын та-

риалдааны үүргийг нэгэн хэвийн хэвлэсэн хуудсаар авч тооцоо судалгаа, бодит дүгнэлт хийгээгүй адил хувь, тоогоор бичиж, дээрээс нь шууд зохион байгуулан авахуулсан нийтлэг дутагдал байна.

Тэрчилэн үүрэг амлалт нь урьд оны амжилтын хэмжээнд хүрэхгүй байгаагийн зэрэгцээгээр малчин хооронд хэл уралдаан байгуулах, уралдааны гэрээтэй ажиллуулах, мал аж ахуйн мэргэжилтэн, бусад сэхээтнүүдээр бригад суурь малчдыг хариуцуулан ажиллуулах бүтээлч төлөвлөгөө зохиогдох ажил огт хийгдээгүй байна.

Иймээс малчид төлчдийн дунд зохиож байгаа социалист уралдааныг улам чанаржуулж хэлбэр агуулгыг баяжуулан 2—5 жилээр тооцоотой үүрэг авахуулахад анхаарах нь зүйтэй байна.

Манай тусгай сурвалжлагч Б.ТОГООХҮҮ

риалалтын бэлтгэл ажил, бараа, ном борлуулах, ангийн үс, түүхий эд бэлтгэлт, сумын соёл үйлчилгээний байгууллагуудын төлөвлөгөөний биелэлт зэрэг 24 үзүүлэлтээр Угтаал сум-САА сум хоорондын уралдаанд түрүүлэв.

Ш. ДЭГИДДОРЖ

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ